

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Талын илч ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК Захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com Аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 90109012, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govsumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
“ТАЛЫН ИЛЧ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ А.БАТЖАРГАЛ ТАНАА

А.Батжаргал № 14

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020023

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2023 оны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 92 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****/төгрөгөөр/**

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,528,116.49	2,906,812.29
2	Дансны авлага	43,752,036.63	41,522,401.99
3	Татвар, НДШ-ийн авлага	3,389,935.30	1,400.10
4	Бусад авлага	405,074.20	721,280.00
5	Бараа материал	78,364,570.29	61,444,833.47
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	153,439,732.91	106,596,727.85
7	Үндсэн хөрөнгө	1,302,166,372.26	1,375,294,804.61
8	Биет бус хөрөнгө	54,574,000.00	54,380,166.64
9	Салбарт оруулсан хөрөнгө оруулалт	-	-
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,356,740,372.26	1,429,674,971.25
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,510,180,105.17	1,536,271,699.10
12	Дансны өглөг	879,139.75	5,684,353.20
13	Татварын өр	11,931,510.65	3,940,875.08
14	Бусад богино хугацаат өр төлбөр	378,970.00	-
15	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,189,620.40	9,625,228.28
16	Бусад урт хугацаат өр төлбөр	370,646,533.85	370,646,533.85
17	Урт хугацаат өр төлбөрийн дүн	370,646,533.85	370,646,533.85
18	Өр төлбөрийн нийт дүн	383,836,154.25	380,271,762.13
19	Өмч: - төрийн	1,572,400,240.20	1,572,400,240.20
20	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	86,304,329.64	86,304,329.64
21	Хуримтлагдсан ашиг	(532,360,618.92)	(502,704,632.87)
22	Тайлангийн үеийн ашиг	60,618,584.62	29,299,077.26
23	Өмнөх үеийн ашиг	(592,979,203.54)	(532,003,710.13)
24	Эздийн өмчийн дүн	1,126,343,950.92	1,155,999,936.97
25	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,510,180,105.17	1,536,271,699.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**/төгрөгөөр/**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	510,948,603.28	506,789,022.08
2	Борлуулалтын өртөг	339,055,200.00	421,050,926.20
3	Нийт ашиг(алдагдал)	171,893,403.28	85,738,095.88
4	Бусад орлого	72,877,518.45	152,681,322.84
5	Орлогын дүн	72,877,518.45	152,681,322.84
6	Борлуулалт, маркетингийн зардал	16,057,762.97	27,147,611.49
7	Ерөнхий ба удирдлагын зардал	146,132,856.84	162,796,009.79
8	Бусад зардал	15,226,319.01	11,917,478.13
9	Зардлын дүн	177,416,938.82	201,861,099.41

10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(3,999,999.96)
11	Олз, гарзын дүн	-	(3,999,999.96)
12	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	67,353,982.91	32,558,319.35
13	Орлогын татварын зардал	6,735,398.29	3,259,242.09
14	Татварын дараах ашиг (алдагдал)	60,618,584.62	29,299,077.26
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	60,618,584.62	29,299,077.26

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(592,979,203.54)	1,065,725,366.30
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	60,618,584.62	60,618,584.62
3	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(532,360,618.92)	1,126,343,950.92
4	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	356,908.79	356,908.79
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	29,299,077.26	29,299,077.26
6	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(502,704,632.87)	1,155,999,936.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Мөнгөн орлогын дүн (+)	541,416,196.44	566,986,405.94
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	539,336,196.44	546,896,248.33
3	Бусад мөнгөн орлого	2,080,000.00	20,090,157.61
4	Мөнгөн зарлагын дүн (-)	515,865,755.03	546,707,710.14
5	Ажиллагчдад төлсөн	176,894,464.83	216,387,947.54
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,865,823.08	40,264,357.43
7	Бараа материал худалдан авахад төлсөн	102,830,896.23	60,355,102.00
8	Ашиглалтын зардалд төлсөн	24,299,459.48	36,357,871.01

9	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	77,574,561.25	82,064,574.00
10	Татварын байгууллагад төлсөн	50,018,719.09	54,875,846.91
11	Даатгалын төлбөрт төлсөн	13,605,715.55	38,229,484.19
12	Бусад мөнгөн зарлага	29,776,115.52	18,172,527.06
13	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,550,441.41	20,278,695.80
14	Мөнгөн зарлагын дүн (-)	200.00	44,900,000.00
15	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	44,900,000.00
16	Бусад	200.00	-
17	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(200.00)	(44,900,000.00)
18	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	25,550,241.41	(24,621,304.20)
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,091,175.41	27,528,116.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,528,116.49	2,906,812.29

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
1	Цалин	302,104,490.00	258,122,877.74	-43,981,612.26
2	Гэрээт олговор	7000,000.00	6,025,000.00	-975,000.00
3	НДШ,ЭМД	43,805,151.00	36,935,905.52	-6,869,245.48
4	Материалын зардал	25,900,000.00	58,692,810.94	32,792,810.94
5	Нүүрсний зарцуулалт	57,000,000.00	47,274,691.76	-9,725,308.24
6	Хөдөлмөр хамгаалал	1,400,000.00	3,033,909.03	1,633,909.03
7	Бичиг хэрийн зардал	750,000.00	1,769,021.41	1,019,021.41
8	Цахилгааны зардал	29,600,000.00	30,092,364.52	492,364.52
9	Гэрээт ажлын төлбөр	1,900,000.00	3,800,549.09	1,900,549.09
10	Томилолтын зардал	32,000,000.00	32,844,290.29	844,290.29
11	Шатахууны зардал	450,000.00		-450,000.00
12	Газрын төлбөр	248,220.00	250,293.00	2,073.00
13	Тээврийн хэрэгслийн татвар	352,600.00	352,600.00	0.00
14	ҮХХТатвар	2,609,400.00	1,158,429.44	-1,450,970.56
15	Агаарын бохирдол	26,500.00	30,000.00	3,500.00
16	Авто зам ашиглалтын төлбөр	34,000.00	81,000.00	47,000.00
17	Тээврийн хэрэгслийн оношилгоо		112,545.45	112,545.45
18	Зохицуулах үйлчилгээний хөлс	1,560,000.00	6,435,600.00	4,875,600.00
19	Үндсэн хөрөнгийн элэгдэл	55,200,000.00	98,949,858.87	43,749,858.87
20	Усны шинжилгээний төлбөр	338,400.00	156,900.00	-181,500.00
21	Даатгалын зардал	600,000.00	2,065,650.00	1,465,650.00
22	Хог хаягдлын төлбөр	600,000.00	600,000.00	0.00
23	Ажилчдын нийгэм хамгаалал	5,700,000.00	14,85,863.63	-4,214,136.37
24	Дулааны зардал		11,929,500.00	11,929,500.00
25	Дулааны зардал	4,704,000.00	2,769,572.72	-1,934,427.28

26	Шуудан холбооны зардал	2,650,000.00	121,250.00	-2,528,750.00
27	Тээврийн зардал		641,915.27	64,1915.27
28	Ахмадын зардал	4,500,000.00	212,800.00	-4,287,200.00
29	Аудитын төлбөр	2,000,000.00	1,960,000.00	-40,000.00
30	МНААҮХолбооны гишүүнчлэлийн татвар	1,600,000.00	1,500,000.00	-100,000.00
31	Байгууллага хөгжүүлэлтийн зардал	2,500,000.00	148,072.73	-2,351,927.27
32	Сургалтын зардал	1,350,000.00	800,000.00	-55,0000.00
33	Орон нутгийн санхүүжилт хийж буй ажлын зардал		11,917,478.13	11,917,478.13
34	Банкны үйлчилгээний зардал		258,185.16	258,185.16
35	Бусад зардал	4,000,000.00	383,090.91	-3616,909.09
36	Тайлант үеийн олз, гарз		3,999,999.96	3,999,999.96
37	Орлогын албан татвар	3,000,000.00	3,259,242.09	259,242.09
	ЗАРДЛЫН НИЙТ ДҮН:	595,482,761.00	630,171,267.66	34,688,506.66
1	Дулааны орлого	483,286,000.00	458,812,307.50	24,473,692.47
2	Цэвэр, бохир усны орлого	14,791,440.00	46,417,946.37	31,626,506.37
3	Бусад орлого		23,386,565.02	23,386,565.02
4	Үндсэн хөрөнгө орлогот авсан орлого	26,922,560.00	130,853,526.00	103,930,966.00
	ОРЛОГЫН НИЙТ ДҮН:	525,000,000	659,470,344.9	134,470,344.92
	АШИГ/ АЛДАГДАЛ	-70,482,761.00	29,299,077.26	99,781,838.26

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь “Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа” бөгөөд тайлант жилийн үйл ажиллагааны зорилго нь “Хэрэглэгчдийг дулаан, хэрэглээний цэвэр усаар тогтмол найдвартай хангах болон бохир усыг татан зайлуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дүгээр сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор 24 орон тоо баталж, 19 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж, 6 орон тоо дутуу ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу тус байгууллага нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна. Гэсэн хэдий ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал: Үнэ төлбөргүй орж ирсэн орлогыг хэрхэн бүртгэх талаар байгууллагын бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,091.6 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,528.1	2,906.8	-24,621.3
Авлага	47,547.0	42,245.1	-5,301.9
Бараа материал	78,364.6	61,444.8	-16,919.8
Үндсэн хөрөнгө	1,356,740.4	1,429,674.9	72,934.6
Нийт хөрөнгө	1,510,180.1	1,536,271.7	26,091.6
Дансны өр	13,189.6	9,625.2	-3,564.4
Хойшлогдсон татварын өр	370,646.53	370,646.53	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,572,400.2	1,572,400.2	0.0
Дахин үнэлгээний нэмэгдэл	86,304.3	86,304.3	0.0
Хуримтлагдсан ашиг	-532,360.6	-502,704.6	29,656.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,510,180.1	1,536,271.7	26,091.6

Дээрх хүснэгтээс харахад:

- Үйл ажиллагааны үр дүнгээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24,621.3 мянган төгрөгөөр буурсан байна.
- Дансны авлагын үлдэгдэл 42,245.1 мянган төгрөг буюу 12.5 хувиар буурсан нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагын авлага мөн татварын илүү төлсөн авлагууд буурсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 61,444.8 мянган төгрөг болж 27.5 хувиар буурсан нь сэлбэг материалын нөөц бүрдүүлэлт бага байсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 72,934.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогдсон байна.
- Өр төлбөр 3,564.4 мянган төгрөг болж 27.0 хувиар буурсан нь татвар, ажилчин албан хаагчдад өгөх өглөгүүд буурсантай холбоотой байна.
- Хуримтлагдсан алдагдал 29,656.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Говьсүмбэр аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 525,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 595,482.8 мянган төгрөгөөр, 70,482.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 659,470.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 626,912.1 мянган төгрөгийн зардал гарган, 32,558.2 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 659,470.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 525,000.0 мянган төгрөг буюу 25.6 хувиар давсан нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон үндсэн хөрөнгийг орлогод авснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 630,171.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 595,482.8 мянган төгрөг буюу 5.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгө данснаас хассан гарз үүссэн мөн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээр элэгдлийн зардал нэмэгдсэн, шатахуун, нүүрс, сэлбэг материалын үнэ нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 29,299.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 99,781.8 мянган төгрөгөөр илүү байгаа нь үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 130,853.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Платиниум прогресс аудит” ХХК-ийн аудитор Б.Дэлгэрмаа гүйцэтгэж, хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг “Платиниум прогресс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтээс 1.5 хувийг сонгож, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2,762.3 мянган төгрөгөөр тооцсон ба санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 1,933.6 мянган төгрөгөөр тогтоож, материаллаг байдлыг дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгадагч байгууллагад хамааралтай 32 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Тус байгууллага нь тайлант жилд 659,470.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 630,171.2 мянган төгрөгийн зардал гарган, 29,299.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллийг ил тод байршуулсан эсэхийг шалгахад зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тус газар нь 2023 онд 23,903.8 мянган төгрөгийн худалдан авалтыг хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан зөрчил гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

2. Талын илч ОНӨААТҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгө 1,522,156.2 мянган төгрөг байгаа бол санхүүгийн тайланд 1,572,400.2 мянган төгрөг буюу 50,244.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.1-д “өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3. Тайлант онд 30,747.6 мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Мөнгөн кассын үйл ажиллагааны журамтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайланд аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалт он тулгаж хийгдсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	2,400.0	2	0.1	66.7
Нийт дүн	3	2,400.0	2	0.1	66.7

Өмнөх оны санхүүгийн аудитаар анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн боловч зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй.

Аудитаар нийт 6,181.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,181.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Талын илч ОНӨААТҮГ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 47,547.0 мянган төгрөгийн авлагатай гарч 2023 онд 42,245.1 мянган төгрөг болж буурсан ч айл өрхөөс авах авлага 6,181.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Айл өрхөөс авах авлагыг барагдуулах ажил зохион байгуулах

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орлого үр дүнгийн тайланг татварын тайлантай тулган шалгахад аймгийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан нийт 370,646.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд бүртгэхдээ хойшлогдсон татварын өр дансанд бүртгэсэн байна. Үнэ төлбөргүй орж ирсэн орлогыг хэрхэн бүртгэх талаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг стандарт, заавар журамд нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулсан алдаа гараагүй.												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Өглөгийн дүн нэмэгдсэн	1	6,181.1					1	6,181.1				
НБББББ-тэй холбоотой	1	0.0					1	0.0				
Дүн	2	6,181.1					2	6,181.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Анхан шатны баримт бүрдэл дутуу					1	23,903.8		
Гэрчилгээн дэх хөрөнгө, тайлан дахь хөрөнгөтэй зөрүүтэй							1	50,244.0
Бэлэн мөнгөний гүйлгээ хийгдсэн							1	30,747.6
Дүн	3	104,895.4			1	23,903.8	2	80,991.6